			Төлбөрийн ээлж

Гүйцэтгэх Захирал: /Захирал/ Банкинд гүйлгээ хийсэн
Тамгаоны....сарын....өдөр
Нягтлан бодогч: /Нягтлан/ тэмдэг, гарын үсэг

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

Нэхэмжлэхийн дугаар : 1250111042990

2025 - 04р
Дугаар
Багахангай

ТАТВАРЫН АЛБА:

Татварын алба: Багахангай
Татварын дэд алба: 2-р хороо
Хайланта хугацаа: 2025 - 4
Төлөх дүн: 149,880.00 ₮
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Төлбөр хураамжийн төрөл: -
Төрлийн задаргаа: -

ТАТВАР ТӨЛӨГЧ:

Регистр /ТТД: 5889782 / 64101478662
Татвар төлөгчийн нэр: Мастермайнинг сервис
Нэхэмжлэх үүсгэсэн огноо: 2025-01-22 12:52:28
Төлөх огноо: 2025-01-22 12:52:28



1250111042990



БАТЛАВ.
МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС ХХК
ЗАХИРАЛ Т.БАЯРБАТ



ХОГ ТЭЭВРИЙН ГЭРЭЭ №2025/

2025 оны 01-р сарын 02-ны/ний өдөр

Багахангай

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хууль, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 14-р тогтоолоор баталсан “Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам”, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 63-р тогтоолоор баталсан “Хот тохижилт, ариун цэврийг сайжруулах талаар байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс дагаж мөрдөх журам” Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 04 дүгээр сарын 19-ний А/15 дугаар тогтоолыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 6248 дугаараар бүртгэснийг хэрэгжүүлэх зорилгоор. Нэг талаас Багахангай дүүргийн **8102155** тоот регистрийн дугаартай “Багахангай тохижилт ОНӨААТҮГ” /цаашид Гүйдэтгэгч гэх/, Нөгөө талаас **5889782** тоот регистрийн дугаартай, Багахангай дүүргийн 2-р хорооны нутаг дэвсгэрт байрлах /цаашид захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын эрх, үүрэг

- 2.1 Монгол Улсын “Хог хаягдлын тухай” хуулийн 41.1 дахь заалтыг үндэслэн аж ахуй нэгж байгууллага, иргэдээс хог хаягдал гаргасны төлбөрийг нэхэмжлэх эрхтэй.
- 2.2 Дүүргийн Татварын хэлтэстэй хамтран хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтийн байдалд тухай бүр хяналт тавьж, төлбөр төлөөгүй болон гэрээ хийгээгүй аж ахуй нэгж, байгууллагуудад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх.
- 2.3 ААН Байгууллагуудад хог хаягдлын талаарах тогтоомжуудыг сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах.
- 2.4 Хог хаягдлыг захиалгын дагуу хугацаанд нь тээвэрлэх ажлыг зохион байгуулах. Аж ахуй нэгж, байгууллага хог хаягдал гаргасны төлбөрийг цаг хугацаанд нь бүрэн төлөөгүй бол “Хог хаягдлын тухай” хууль тогтоомжид зааснаар Татварын улсын байцаагч, дүүргийн 1, 2-р хорооны Засаг дарга нар, Мэргэжлийн хяналтын байцаагч нартай хамтран холбогдох хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авах, санхүүгийн тайлан хүлээн авахгүй байх, мөн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх гэрээг байгуулахгүй байх хуульд заасан бусад арга хэмжээг авна.
- 2.5 Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ыг төлөөлж хог хаягдал, орлогын байцаагч буюу хяналтын ажилтан гэрээ байгуулан, 2% үйлдэж 1%-г гэрээ байгуулсан байгууллагт хүлээлгэн өгнө.

Гурав. Аж ахуй нэгж байгууллагын эрх, үүрэг

- 3.1 Монгол Улсын "Хог хаягдлын тухай" хуулийн 41-р зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн хог хаягдлыг гаргасны төлбөр **84600** төгрөгийг сар бүрийн 25-ны дотор Багахангай Дүүргийн Татварын хэлтсийн Төрийн сан дахь БХД.Хог хаягдлын хураамж нэртэй **100200800947** тоот дансанд төлнө.
- 3.2 Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг графикайн дагуу тогтсон хугацаанд тээвэрлэж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага тавих.
- 3.3 Явуулж байгаа үйлдвэрлэл үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, үйлдвэрлэлийн хог хаягдлын талаарх мэдээллийг Багахангай тохижилт ОНӨААТҮГ-т үнэн зөв мэдээлж байх.
- 3.4 Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө аван ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилчдадаа эзэмшүүлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.
- 3.5 Багахангай тохижилт ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулахдаа байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар авч ирэх.
- 3.6 Иргэн, аж ахуй нэгж байгууллага орчныхоо хог хаягдлыг цэвэрлэх болон зайлуулах, олон нийтийг хамарсан ажилд идэвхитэй оролцох үүрэгтэй.
- 3.7 Иргэн, аж ахуй нэгж байгууллага нь өөрийн эзэмшил, өмчлөлийн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар урьдчилан Багахангай тохижилт ОНӨААТҮГ-т мэдэгдэж гэрээ байгуулан зохих төлбөрийг төлсний үндсэн дээр Багахангай тохижилт ОНӨААТҮГ-аар тээвэрлүүлнэ.
- 3.8 Хог тээвэрлэлтийн гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагыг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 3.9 Иргэн, аж ахуй нэгж байгууллага өмчилж байгаа орчноо зүлэгжүүлж, ногоон байгууламжийг бий болгох, хог хаягдлыг ангилан ялгах талаар санал оруулах тайлан мэдээ гаргаж Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын орлогын байцаагчид мэдээллэх зэргээр хамтарч ажиллана.
- 3.10 Хог хаягдлыг ачиж тээвэрлэхэд саад болохооргүй газарт агуулсан байна. Хөлдүү хогийг захиалагч өөрөө хариуцаж хогийн сав болон орчноос бүрэн суллаж, ачихад бэлтгэсэн байна.
- 3.11 Хог хаягдлын хууль тогтоомж зөрчвөл захиргааны болон эрүүгийн арга хэмжээ авна.
- 3.12 Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 13-р заалтын дагуу зөвшөөрөлгүй, ил задгай хог хаясан иргэнийг 50 нэгжтэй тэнцэх хэмжээний, аж ахуй нэгж байгууллагыг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний мөнгөөр торгож, хохирлыг арилгуулах хуулийн заалтыг дагаж мөрдөх.
- 3.13 Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий холбогдох дээд шатны байгууллага болон Багахангай тохижилт ОНӨААТҮГ-т мэдэгдэж тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх, дарж устган тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан байх.
- 3.14 Хог хаягдлын тухай хуулийн 9.4.12-т заасны дагуу нутаг дэвсгэрийн аж ахуй нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх.
- 3.15 Хог хаягдлын тухай хуулийн 10.2.6.нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох

Дөрөв. Төлбөр тооцоо

- 4.1 Гэрээнд 3.1-д заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй нөхцөлд хугацаа хэтэрсэн хоног тутам 0.5%-ийн алданги тооцно.

- 4.2 Тухайн үеийн үнийн өсөлтөөс хамааралтайгаар үйл ажиллагааны зардал өссөн тохиолдолд талууд тохиролцсоноор хог хаягдал гаргасны болон тээвэрлэлтийн төлбөрт өөрчлөлт оруулан тооцно.
- 4.3 Хог хаягдлыг ачиж тээвэрлэх төлбөрийн үнийн дүнд НӨАТ тооцогдоогүй болно.
- 4.4 Гэрээг 2025 оны 01 сарын 02 ний өдрөөс 2025 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл хугацаатайгаар байгуулав.
- 4.5 Холбогдох байгууллагууд үйл ажиллагаагаа бүр мөсөн зогсоох тохиолдолд уг гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 4.6 Ямар нэг шалтгаанаар үйл ажиллагаагаа зогссон болон түр зогсож байгаа дохиолдолд заавал байцаагчид мэдэгдэх.
- 4.7 Сар бүр төлбөр тооцоо хийхдээ Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын нэхэмжлэх үүсгэснээс эхлэн 3 хоногт багтаан төлбөрөө төлнө.

Тав. Гэрээний үргэлжлэх хугацаа, гэрээг дүгнэх, цуцлах нөхцөл

- 5.1 Талууд хагас бүтэн жилээр гэрээний биелэлтийг дүгнэж, цаашид илүү үр дүнтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлно.
- 5.2 Гэрээний хавсралт №1-ийн үнэлгээнээс хамааран гэрээ сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1 Энэхүү гэрээг гүйцэтгэхэд нөлөөлөх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлд /цас зуд, үер ус, газар хөдлөлт, гал түймэр, нийтийг хамарсан үймээн самуун гэх мэт онц байдлын нөхцөлүүд/ үүссэн тохиолдолд талууд гэрээний үүргээсээ татгалзах эрхтэй ба гэрээний талууд учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхгүй.
- 6.2 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд зөвхөн харилцан тохиролцож эрх тэгш байдал болон гэрээний чөлөөт байдлын зарчим дээр үндэслэнэ.
- 6.3 Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БАГАХАНГАЙ ТОХИЖИЛТ
ОНӨААТҮГ-ЫН
ХОГ ХАЯГДАЛ ОРЛОГЫН БАЙЦААГЧ
..... Ч.Нина /
Хаяг: Багахангай 1-р хороо
Утас: 70491064, 89147703

НЯГТЛАН БОДОГЧ

.....
Хаяг: БХД 2-Р ХОРОО
Утас: 88067702



“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

Огноо: 2025 оны 01 сарын 03
Гэрээний дугаар: Ш-25/001



Хүлээн авагч:
“Цэцүүх Трейд” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо /16010/, Энхтайваны өргөн чөлөө 64/2 тоот “Цэцүүх” оффис, үйлчилгээний төв
Утас: +976 70179777, +976 70180632
Цахим хаяг: www.tsetsuuh.mn
Регистрийн дугаар: 2066521
Цахим шуудан: info@tsetsuuh.mn

Үүсгэгч:
“Мастер Майнинг Сервис” ХХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо /17010/, Надамчдын гудамж, MSN Building office, 3 давхарт 303 тоот
Утас: +976 77113523, +976 88889094
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011503084
Регистрийн дугаар: 5889782
Цахим шvvдан: info@mastermining.mn

БАТЛАВ.
“ЦЭЦҮҮХ ТРЕЙД” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Н.БИЛГҮҮН/

БАТЛАВ.
“МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС” ХХК
ЗАХИРАЛ



/Т.БАЯРБАТ/

2025 оны 01 сарын 03-ний өдөр

№ Ш-25/ *001*
Ү-

Улаанбаатар хот

Нэг талаас **Цэцүүх трейд ХХК** /цаашид “Хүлээн авагч” гэх/ төлөөлж Үйлдвэрийн нягтлан албан тушаалтай Т. Буяндэлгэр, Нөгөө талаас **Мастер Майнинг Сервис ХХК**-г /цаашид “Үүсгэгч” гэх/ төлөөлж Үйлдвэрийн менежер албан тушаалтай Д.Ган-Эрдэнэ бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын **2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”**, **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний агуулга

- 1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
- 1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

- 2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээтэй байна.
- 2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
- 2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
- 2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ **БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг** бүрдүүлж өгнө.
- 2.5. Аюултай хог хаягдлын савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон үүсмалаар ивэрлэсэн байна. Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.

Хуудсыг баталгаажуулсан:

Хуудас 2/10

- 2.6. Үүсгэгч Аюултай хог хаягдлыг “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий Аж ахуй нэгжийн тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлж хүлээн авагчид шилжүүлнэ.

Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

- 3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2025 оны 01 сарын 02 өдрөөс 2026 оны 01 сарын 02 өдрийг хүртэл 1 /нэг/ жилийн хугацаатай байна.
- 3.2. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.3. Энэхүү гэрээний №1-д хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.
- 3.4. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл info@tsetsuuh.mn хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хүлээн авагчийн байранд аюултай хог хаягдал хүргэх хугацааг товлон.
- 3.5. Хүлээн авагч нь үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.
- 3.6. Үүсгэгчийн шилжүүлэх аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхэгийг гэрээний хавсралт №2-д заасан төлбөр тооцооны тарифын дагуу харгалзуулан тооцож тухайн үед шилжүүлэх аюултай хог хаягдлын төлбөрийн хэмжээ гарна.
- 3.7. Талууд гэрээ байгуулах үед үүсгэгч хүлээн авагчид нэг жилд үүсэх аюултай хог хаягдлын төлбөрийн 30 хувийг төлсөнөөр гэрээ баталгаажна.
- 3.8. Үүсгэгчийн эхний нийлүүлэлтээр шилжүүлсэн аюултай хог хаягдлын төлбөр гэрээ байгуулах үед төлсөн төлбөрөөс илүү гарсан бол урьд төлсөн төлбөрийг тооцуулж үүн дээр илүү гарсан төлбөрийг нэмж төлнө, бага бол дараагийн нийлүүлэлт дээр үлдсэн төлбөрөө хасч тооцуулна.
- 3.9. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.
- 3.10. Үүсгэгч нь шилжүүлсэн аюултай хог хаягдлын төлбөрийг хүлээн авагчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор Цэцүүх трейд ХХК-ийн Голомт банкны 1715132986 тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу төлнө.
- 3.11. Үүсгэгч нь хүлээн авагчийн тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлүүлж, хүргэлтийн цэг дээр хүргүүлж болно. Хүлээн авагчийн тээврийн хэрэгслээр хог хаягдал ачиж, тээвэрлүүлэх тохиолдолд тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу зохих төлбөрийг төлнө.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Үүсгэгчийн эрх, үүрэг:
- 4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.
- 4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 3/10

- 4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 4 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө 1 хувь, тээвэрлэгчид 1 хувь, хүлээн авагчид 2 хувийг илгээж, хүлээн авагчаас хүлээн авсан гарын үсэг, тамга тэмдэг дарагдсан 1 хувь дагалдах бичгийг буцаан авна.
- 4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.
- 4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулна.
- 4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.
- 4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлснээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.
- 4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.
- 4.2 Хүлээн авагчийн эрх, үүрэг
- 4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах эрхтэй.
- 4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.
- 4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.
- 4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.
- 4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.
- 4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авснаас хойших түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.
- 4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

- 5.1. Үүсгэгч гэрээгээр тохиролцсон хугацаандаа аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг буюу Төв аймаг, Сэргэлэн сум, 1-р багийн нутаг дэвсгэрт орших “ЦЭЦҮҮХ ПЕ&ПП ДАХИН БОЛОВСРУУЛАХ ЭКО ҮЙЛДВЭР”-г хүргэнэ.
- 5.2. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.
- 5.3. Үүсгэгч аюултай хог хаягдлаа “Аюултай хог хаягдал” тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжийн тусгай зориулалтын, зохих тэмдэг тэмдэглэгээтэй тээврийн хэрэгслээр ачиж, тээвэрлүүлэн Хүлээн авагчид хүргэж өгнө.
- 5.4. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 4/10

- 5.5. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

Зургаа. Өмчлөх эрх шилжих

- 6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид дагалдах бичгээр хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.
- 6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр дагалдах бичгээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.
- 6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.
- 7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.
- 7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.
- 7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.
- 7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлсэнээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.
- 7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 5/10

- зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.
- 8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.
- 8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал утсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойших эрсдэлийг хүлээн авагч хариуцна.
- 8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

Ес. Бусад зүйл

- 9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Үүсгэгч талыг төлөөлж:
Мастер Майнинг Сервис ХХК -ийн
Үйлдвэрийн менежер

 / Д. Ган-Эрдэнэ /

Суурин утас: 77113523

Гар утас: 99082866

Регистер: 5889782

УБ гэрчилгээний дугаар: 9011503084

Химийн бодис ашиглах, импортлох тусгай
зөвшөөрлийн дугаар: 846

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
15-р хороо /17010/, Надамчдын гудамж,
MSN Building office, 3 давхарт 303 тоот
Email хаяг: ganerdene.d@mastermining.mn

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн нягтлан

 / Т. Буяндэлгэр /

Суурин утас: 70189778

Гар утас: 99057786

Регистер: 2066521

УБ гэрчилгээний дугаар: 9011026056

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001

Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр

Email хаяг: Buyanaa@tsetsuuh.mn

Шуудангийн хаяг: ПХ-1138



Хуудсыг баталгааж

Хуудас 6/10

“Цэцүүх Трейд” ХХК, “Мастер Майнинг Сервис” ХХК-ийн хооронд
байгуулсан Аюултай хог хаягдал шилжүүлэх
2025 оны дугаар сарын -ны өдрийн
Ш-25/..... тоот гэрээний Хавсралт № 01

2025-2026 онд МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС ХХК-ийн ЖИЛД УСТГУУЛАХ
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ХЭМЖЭЭ

№	Тухайн сав баглаа агуулагдаж бодисын мэдээлэл	Аюултай хог хаягдлын савны төрөл	Жилд үүсэх тоо хэмжээ / ш, кг, тонн /			
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
1	Аммиакын шүү	Шуудай	1000кг	1000кг	1000кг	1000кг








Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 7/10

ХИМИЙН ХОРТОЙ БОДИС ХАДГАЛСАН ХАЯГДАЛ ХУВАНЦАР САВ
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ТАРИФ
(тээврийн зардал багтаагүй үнэ болно)

№	Үйлчилгээний төрөл	Хог хаягдлын төрлийн код	Зураг	Хэмжих нэгж	Нэгж үнэ төг
1	Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр 10л, 25л, 50л, 60л,	150109		1кг	1150
2	Химийн хуванцар торх 100л	150109		1ш	4800
3	Химийн хуванцар торх 200л	150109		1ш	7900
4	Химийн хуванцар ИВС танк 1000л	150109		1ш	26000
5	Полипропилен уут, шуудай, 25кг, 50 кг, 1 тн big bag шуудай/	150109		1кг	1380

Тайлбар. 1. Дээрх үнэд химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар савыг хадгалах, дахин боловсруулах үйлчилгээний хөлс бөгөөд тээврийн зардал ороогүй болно.

2. Химийн хортой бодис хадгалсан хуванцар савыг хүлээн авагч авахдаа жинлэж авах ба бага хэмжээтэй тохиолдолд тн-ийг килограммд шилжүүлж тооцно.



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 8/10

ҮҮСГЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:
ТӨЛӨӨЛЖ:

Үүсгэгч талыг төлөөлж:
Мастер Майнинг Сервис ХХК -ийн
Үйлдвэрийн менежер

 / Д.Ган-Эрдэнэ /

Суурин утас: 77113523
Гар утас: 99082866
Регистер: 5889782
УБ гэрчилгээний дугаар: 9011503084

Ашиглах тусгай зөвшөөрлийн дугаар: 846

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
15-р хороо /17010/, Наадамчдын гудамж,
MSN Building office, 3 давхарт 303 тоот

Email хаяг: ganerdene973@gmail.com

ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫГ

Хүлээн авагч талыг төлөөлж:
Цэцүүх Трейд ХХК-ийн
Үйлдвэрийн нягтлан

 / Т. Буяндэлгэр /

Суурин утас: 70189778
Гар утас: 99057786
Регистер: 2066521
УБ гэрчилгээний дугаар: 9011026056
Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000007
Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо,
Энхтайвны өргөн чөлөө – 64/2, Цэцүүх
Трейд ХХК-ийн оффис, үйлчилгээний байр
Email хаяг: Buyanaa@tsetsuuh.mn
Шуудангийн хаяг: ШХ-1138



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 9/10

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ
№

Дагалдах бичгийн дугаар:

/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл: Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Y- Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: Мастер Майнинг Сервис ХХК								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн: Овог нэр Албан тушаалтан Гарын үсэг: Огноо: 2024 он сар өдөр								
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл: 1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлаганы бүлэг	Савны дугаар / Төрөл		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
1								
2								
3								
4								
4. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:								
6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч : 1. Овог нэр: Гарын үсэг: 2025 он сар өдөр								
7. Үл зохицол:								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл: Аж ахуйн нэгжийн нэр: ЦЭЦҮҮХ ТРЕЙД ХХК Цэцүүх трейд ХХК бүртгэлийн дугаар: Б-00007 Y-001123 Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Овог нэр : Цэцүүх трейд ХХК Албан тушаал Гарын үсэг/ тамга / Огноо 2025 он сар ... өдөр								



Хуудсыг баталгаажуулсан:



Хуудас 10/10

БАТЛАВ.

АЛЬФА МЕДИКАЛ ЭМНЭЛЭГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТЗАЯА



**ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ҮЗЛЭГ ХИЙХ ГЭРЭЭ**

2024 оны 12 дугаар сарын 06 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд болох Альфа медикал центр ХХК /цаашид "Гүйцэтгэгч" гэх/ түүнийг төлөөлөн Альфа медикал Эмнэлгийн гүйцэтгэх захирал Ц.Батзаяа, нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох Мастер майнинг сервис ХХК /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал ажилтай Т. Баярбат нар /цаашид хамтад нь "Талууд" гэх/ нь дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Гэрээний зорилго нь нийт ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хугацаат үзлэг, шинжилгээг хийж гүйцэтгэх, Захиалагчийн хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай танилцах, эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт, зөвлөмж гаргах болон заавар, зөвлөмж өгөх.
- 1.2 Захиалагч нь бодитоор, зохих ёсоор гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан ажлын хөлсийг төлөх
- 1.3 Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага болон тэдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хийгдэх ажил, гүйцэтгэх хугацаа

- 2.1 Гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг ажил гүйцэтгэх гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 60 хоногийн дотор хийж гүйцэтгэх үүрэгтэй.
- 2.2 Гүйцэтгэгч талын батлагдсан эрүүл мэндийн хуудсыг үндэслэл болгож эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон үзлэг шинжилгээнүүдийг хийнэ.
- 2.3 Гүйцэтгэгч нь компанийн ажиллагсдыг гэрээнд заагдсан үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, үзлэгийг чанартай гүйцэтгэж, ажиллагсдын дунд тохиолдож буй ердийн өвчлөл болон мэргэжлийн өвчнийг илрүүлэн оношлох
- 2.4 Ажиллагсдыг тухайн ажилдаа эрүүл мэндийн хувьд тэнцэх эсэхэд мэргэжлийн тохироо, дүгнэлт гаргах
- 2.5 Мэргэжлийн өвчтэй байж болзошгүй хүмүүсийг эмч нарын зөвлөгөөнөөр хэлэлцэж, асуудлыг шийдэх

Гурав. Төлбөрийн нөхцөл

- 3.1 Эрүүл мэндийн үзлэгт 27 хүнийг 227.000 төгрөгийн багц шинжилгээд хамруулна. Нийт төлбөр 6,129,000 болно.
- 3.2 Төлбөрийг шинжилгээнд орохоос өмнө ХААН банк 5129089580 (Альфа медикал центр РД:6803601) дансанд шилжүүлсэн байна.

- 3.3 Эрүүл мэндийн хугацаат үзлэг шинжилгээнд орсон ажилчидын үзлэгийн төлбөрийг тухайн байгууллага төлнө.

Дөрөв. Захиалагчийн үүрэг, хариуцлага

- 4.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлд заасны дагуу ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг бүрэн хариуцан, энэхүү гэрээнд заасан үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.
- 4.2 Захиалагч тал нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тус үйлдвэрийн эрхэлж буй ажил мэргэжлийн онцлогийг харгалзан мэргэжлийн байгууллагаас хийгдэх эрүүл мэндийн бүрдмэл үзлэг, шинжилгээнд ажиллагсдыг бүрэн хамруулах үүрэгтэй.
- 4.3 Хугацаат үзлэгт орох ажилчдын мэдээллийг урьдчилан мэдээлж байх
- 4.4 Гүйцэтгэгч талаас эмнэлгийн үзлэг үйлчилгээг хэвийн явуулахтай холбоотойгоор өгсөн зөвлөмж зааврыг дагаж мөрдөнө.
- 4.5 Эрүүл мэндийн үзлэг, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтээ Гүйцэтгэгч талд тавих эрхтэй.
- 4.6 Захиалагч нь чанарын шаардлага хангаагүй ажил гүйцэтгэлийг хүлээж авахгүй байх эрхтэй ба чанарын дутагдлыг арилгахыг шаардах эрхтэй.
- 4.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 4.8 Захиалагч тал нь ирэх буцах тээврийн зардал, байр хоолны зардлыг тус тус хариуцна.

Тав. Гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага

- 5.1 Гүйцэтгэгч талаас илгээсэн эрүүл мэндийн үзлэгийн хуудсыг үндэслэж үзлэг, шинжилгээг чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж, эрүүл ахуйн шаардлага хангасан үйлчилгээгээр үйлчилнэ.
- 5.2 Гүйцэтгэгч нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардлагатай, орчин үеийн, эвдрэл гэмтэлгүй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан, ажлын аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, бэлэн байдлыг хангах үүрэгтэй.
- 5.3 Үзлэгийн багийн эмч нар үзлэгийг чанартай хийж, эрүүл мэндийн хуудас болон амбулаторийн карт дээр үзлэгийн хариуг тодорхой бичин хүн тус бүрийн эмчлэн сэргийлэх картад эмчилгээний заавар, зөвлөмжийг зааж бичиж өгнө.
- 5.4 Эрүүл мэндийн үзлэг үйлчилгээтэй холбоотой асуудлаар Захиалагч талд хандах эрхтэй.
- 5.5 Үзлэгийн төгсгөлд эмч тус бүр үзлэгийн дүн, зонхилон тохиолдож буй өвчлөлийг хэрхэн бууруулах талаар зөвлөмжийг гаргах ба үзлэгийг багийн ахлагч нэгтгэн, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнг илтгэх хуудсаар дүнгийн хурал хийж Захиалагч талд хүлээлгэн өгнө.
- 5.6 Захиалагчийн ажлын байранд ажиллах явцдаа хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журам, зааврыг чанд мөрдөж ажиллах ба үүнээс үүссэн аливаа хариуцлагыг өөрөө хариуцна.
- 5.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1 Талууд энэ гэрээний үүргийг биелүүлэх ба харилцан бие биеэ хүндэтгэж хамтран ажиллана.
- 6.2 Гүйцэтгэгч нь гэрээгээр тохирсон хугацаанд ажлыг гүйцэтгээгүй, доголдолтой гүйцэтгэсэн (эрүүл мэндийн хангалттай тусламж үзүүлж чадаагүй, хийгдэх ёстой шинжилгээг орхигдуулсан, мэргэжлийн зөвлөгөөг хангалттай өгөөгүй,

дүгнэлт, шинжилгээ, оношилгоо, үзлэгийг бодит байдалд нийцүүлээгүй, шаардлага хангаагүй гаргасан) тохиолдолд ажлыг үнэ төлбөргүйгээр дахин гүйцэтгэнэ.

- 6.3 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад нөгөө талын нууцлалын чанартай мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй, ашиг олох зорилгоор ашиглахгүй байх үүргийг хүлээнэ.
- 6.4 Энэхүү гэрээний 6.2, 6.3-т заасан нөхцөлийг зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор нөгөө талд учруулсан аливаа хохирлыг буруутай тал бүрэн барагдуулна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 7.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Найм. Бусад зүйл

- 8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн уг гэрээ хүчин төгөлдөр болно.
- 8.2. Энэхүү гэрээг Монгол хэл дээр 2 хувь үйлдэж, Талууд тус бүр нэг хувийг хадгалах ба хувь тус бүр адил хүчинтэй байна.
- 8.3. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг Талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэх ба тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих хууль, тогтоомжийн дагуу маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 8.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээнд бичгээр үйлдсэн нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЛЬФА МЕДИКАЛ ЭМНЭЛЭГИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.БАТЗАЯА

Утас: 93444493

МАСТЕР МАЙНИНГ СЕРВИС ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.БАЯРБАТ

Утас: 88889094



"МастерМайнингСервис" ХХК ажилчдад хийгдсэн урьдчилан сэргийлэх үзлэгийн тайлан

2025 оны 02 сарын 4,6,13нд Альфамедикал эмнэлэгт уул уурхайн "МастерМайнингСервис" ХХК-ийн ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулав. Уг ажлын хүрээнд "МастерМайнингСервис" ХХК нийт 25 хүн лабораторийн шинжилгээнд хамрагдсан. Үүнд:

- ЦДШ
 - ШЕШ
 - Биохими
 - Элэгний В, С шинжилгээ
 - H.Pylori
- шинжилгээний сорьц авч шинжилснээс

16 хүн Хелико бактерийн халдвартай, 7 хүн элэгний В, С вирусын халдвартай, 8 хүн элэгний үйл ажиллагаа, 1 хүн нойр булчирхайн алдагдалтай, 3 хүний цусан дахь сахарын хэмжээ ихэссэн, 1 хүн цус багадалттай, 3 хүн цусны өтгөрөлтэй байна.

Мөн 25 хүн хэвлийн болон бамбайн хэт авиан шинжилгээ, цээжний рентген зураг, зүрхний цахилгаан бичлэг хийсэн.

Дүрс оношилгооны тасгаар

- Хэвлийн хэт авиа
- Бамбайн хэт авиа
- Цээжний рентген зураг авсан.

Бамбайн хэт авиан шинжилгээгээр 4 хүн бамбайн зангилаатай байсан ба 2 хүн нь хүнд хэлбэрийн зангилаатай байсан тул дараагийн шатны эмнэлэгт үзүүлэхийг зөвлөсөн.

Хэвлийн хэт авиан шинжлгээгээр элэгний томролтой 5 хүн, элэгний хатууралтай 1, бөөрний чулуутай 2 байсан байна.

Зүрхний цахилгаан бичлэгийн шинжилгээнд зүрхний синусын брадикарди 3 хүнд илэрсэн.

Мэдрэл, доторын эмчийн үзлэг хийгдлээ. 3 өвчтөнд ХӨСҮТ-ийн элэгний клиникийн эмчийн хяналтанд оруулах, вирусын ачаалал тоолох шинжилгээнд хамруулж вирусын эсрэг эмчилгээнд оруулах. 2 өвчтөнд 3-р эмнэлэгийн зүрх судасны эмчтэй холбож өгөөд нарийн шинжилгээнд орохоор боллоо.

Нэгдсэн хариу бичсэн эмч  Ц.Батзаяа



